



БУЛГАН АЙМАГ
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС


63082 Булган аймаг, Булган сум, Цогт хунтайжийн талбай,
Утас/Факс: (976) 7034 2957, E-mail: bulgan_nd04@yahoo.com

2015.09.25 № 1/401
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАРТ

Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх
ЭХМК-ын төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг
сонгон шалгаруулах урилгыг аймгийн албан ёсны
вэб сайтад мэдээлж бидний ажилд туслана уу.

Хавсралт 2 хуудас

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Г.БОЛОРМАА

ТЗУХ
Даргын албан үүргийг
төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг
сонгон шалгаруулах урилгыг
аймгийн албан ёсны вэб сайтад
мэдээлж бидний ажилд туслана уу.

**ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛИЙН ЭМЧ
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА**

2015.09.21

Булган сум

Засгийн газрын 2015 оны "Дүрэм шинэчлэн батлах тухай" 11 тоот тогтоолоор батлагдсан "Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм"-ийн 1 дэх хэсгийн 1.2. дахь заалт, 3 дахь хэсгийн 3.1, 3.3, 3.4-т заасныг үндэслэн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Аймгийн Эмнэлэг Хөдөлмөрийн Магадлах Комиссын төрөлжсөн мэргэжлийн сэтгэц, дотор, мэс заслын эмчийн сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

Сонгон шалгаруулалтын дугаар 01

Булган аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын төрөлжсөн мэргэжлийн эмчийн сонгон шалгаруулалтанд оролцохыг урьж байна.

Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нь тухайн мэргэжлийн дагуу иргэн (даатгуулагч)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох, сунгах, цуцлах үйл ажиллагаанд оролцох, шинжилгээ, үнэлгээ хийх үндсэн чиг үүрэгтэй ажиллана.

Төрөлжсөн мэргэжлийн эмчид тавигдах ерөнхий шаардлага:

- Мэргэшлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй;
- Нийтийн эрх ашиг, шударга журмыг дээдэлдэг байх
- Мэргэжлийн алдаа, ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй;
- Багаар ажиллах, үнэлгээ, дүгнэлт өгөх чадвартай;
- Ял шийтгүүлж байгаагүй;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шаардлага хангасан байна.

Бүрдүүлэх материал:

- Нэр дэвшүүлсэн байгууллагын санал, ажил байдлын тодорхойлолт
- Нэр дэвшигчийн өөрийн хүсэлт;
- Анкет (төрийн албан хаагчийн 1-р маягтаар);
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын диплом, мэргэжлийн болон үйл ажиллагаатай холбоотой материалын хуулбар;
- 3x4 хэмжээтэй 2 хувьцээж зураг;
- Аймгийн хэмжээний хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах хөтөлбөр, төлөвлөгөө

- Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчид тавигдах шаардлагыгхангаагүйболон бүрдүүлэх материалыг дутуу бүрдүүлсэн мэргэжилтнийг сонгон шалгаруулалтанд бүртгэхгүй.

Хугацаа:

Нэр дэвшигчийн материалыг 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 09 цаг 00 минут хүртэл Булган аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нарийн бичиг Б.Мөнгөнчимэг /Утас 99023357, Нэгдсэн эмнэлгийн 2 давхарт дүн бүртгэл, статистикийн өрөө/ бүртгэнэ.

Сонгон шалгаруулалтыг 2015 оны 10 сарын 24 өдрийн 14:00 цагт Аймгийн Засаг Даргын Тамгын Газрын Зөвлөлийн өрөөнд явуулна.

Сонгон шалгаруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доорх утсаар авна уу.

Утас: 70342957, 99344884, 96987444. 96689098.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС